



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/259-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 6 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЛХАГВАЖАВ ТАНАА

2024.08.29 № САА-2024/1259-6А-6А-1113
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мандал сумын Түнхэл тосгоны 6 дугаар цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 21,578.9 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,329,463.44	90,283,630.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,672,874.29	63,277,481.58
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,672,874.29	63,277,481.58
31210	Төгрөг	2,672,874.29	63,277,481.58
31211	Төрийн сангийн харилцах	2,672,874.29	63,277,481.58
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,656,589.15	27,006,149.15
35400	Хангамжийн материал	19,656,589.15	27,006,149.15
35410	Бичиг хэргийн материал	0.00	1,915,500.00
35420	Аж ахуйн материал	13,600,345.50	13,616,345.50
35460	Хүнсний материал	246,942.25	1,614,002.25
35470	Бусад хангамжийн материал	5,809,301.40	9,860,301.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,138,499,444.53	1,128,242,906.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,138,499,444.53	1,128,242,906.59
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	1,121,874,444.43	1,111,867,906.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,130,074,193.00	1,130,074,193.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,210,440.76	-104,345,313.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	86,049,058.64	101,039,058.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,949,986.53	-48,873,523.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,612,586.00	60,969,086.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,302,831.20	-40,693,699.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,339,592.00	14,339,592.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,970,426.72	-2,874,186.80
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	2,232,700.00	2,232,700.00
39300	Биет бус хөрөнгө	16,625,000.10	16,375,000.14
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-624,999.90	-874,999.86
39303	Бусад биет бус хөрөнгө	16,000,000.00	16,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,160,828,907.97	1,218,526,537.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,160,828,907.97	1,218,526,537.32
51	Засгийн газрын хувь оролцоо	1,160,828,907.97	1,218,526,537.32
51100	Засгийн газрын оруулсан капитал	97,199,969.64	97,199,969.64
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	97,199,969.64	97,199,969.64
51200	Хуримтлагдсан үр дүн	1,048,408,785.54	1,106,106,414.89
51210	Өмнөх үеийн үр дүн	-112,378,291.31	1,048,408,784.45
51220	Тайлант үеийн үр дүн	1,160,787,076.85	57,697,630.44
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,220,152.79	15,220,152.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,160,828,907.97	1,218,526,537.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,763,453,213.09	862,933,016.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,184,683,185.97	10,400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,184,683,185.97	10,400,000.00
120009	Бусад орлого	0.00	10,300,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,167,896,518.82	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	16,786,667.15	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	578,770,027.12	852,533,016.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	504,967,400.00	787,109,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	504,967,400.00	787,109,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,802,627.12	65,423,716.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,802,627.12	65,423,716.89
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	602,666,136.24	805,235,386.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,666,136.24	805,235,386.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602,666,136.24	791,209,086.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,240,084.67	528,261,944.83
210101	Үндсэн цалин	293,412,167.70	389,387,960.88
210102	Нэмэгдэл	84,591,802.48	120,603,461.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	17,236,114.49	18,270,522.55
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,046,631.12	71,499,406.79
210201	Тэтгэврийн даатгал	33,365,231.12	48,709,639.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,881,800.00	5,730,845.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,174,700.00	4,566,316.78
210204	Ажилгүйдлийн даатгал	870,011.11	1,129,782.40
210205	Эрүүл мэндийн даатгал	7,754,888.89	11,362,822.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,420,841.70	61,957,716.89
210301	Гэрэл, цахилгаан	6,213,077.70	8,823,015.77
210302	Түлш, халаалт	35,659,244.00	44,992,651.12
210303	Цэвэр, бохир ус	8,548,520.00	8,142,050.00
2105	Нормативт зардал	62,867,518.00	79,147,800.00
210502	Хоол, хүнс	62,867,518.00	79,147,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,696,100.00	3,465,600.00
210604	Урсгал засвар	1,696,100.00	3,465,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	494,006.46	284,014.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	494,006.46	284,014.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,900,954.29	46,592,603.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,360,500.00	12,498,566.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,143,380.00	2,491,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,397,074.29	31,603,037.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	14,026,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	14,026,300.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	14,026,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,160,787,076.85	57,697,630.44
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,160,787,076.85	57,697,630.44

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	578,770,027.12	862,833,016.89		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	10,300,000.00		
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	10,300,000.00		
120009	Бусад орлого	0.00	10,300,000.00		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	578,770,027.12	852,533,016.89		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	504,967,400.00	787,109,300.00		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	504,967,400.00	787,109,300.00		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,802,627.12	65,423,716.89		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,802,627.12	65,423,716.89		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	576,097,152.83	780,881,909.60		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	576,097,152.83	780,881,909.60		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	576,097,152.83	766,855,609.60		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,240,084.67	528,261,944.83		
210101	Үндсэн цалин	293,412,167.70	389,387,960.88		
210102	Нэмэгдэл	84,591,802.48	120,603,461.40		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00		
210104	Урамшуулал	17,236,114.49	18,270,522.55		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,004,800.00	71,499,407.88		
210201	Тэтгэврийн даатгал	33,323,400.00	48,709,640.56		
210202	Тэтгэмжийн даатгал	3,881,800.00	5,730,845.94		
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,174,700.00	4,566,316.78		
210204	Ажилгүйдлийн даатгал	870,011.11	1,129,782.40		
210205	Эрүүл мэндийн даатгал	7,754,888.89	11,362,822.20		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,408,841.70	61,957,716.89		
210301	Гэрэл, цахилгаан	6,213,077.70	8,823,015.77		
210302	Түлш, халаалт	35,647,244.00	44,992,651.12		
210303	Цэвэр, бохир ус	8,548,520.00	8,142,050.00		
2105	Нормативт зардал	62,818,940.00	80,514,860.00		
210502	Хоол, хүнс	62,818,940.00	80,514,860.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,696,100.00	3,466,000.00		
210604	Урсгал засвар	1,696,100.00	3,466,000.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	494,006.46	284,014.00		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	494,006.46	284,014.00		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,434,380.00	20,871,666.00		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,135,000.00	16,566,400.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,299,380.00	4,305,266.00		

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		0.00	14,026,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		0.00	14,026,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		0.00	14,026,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		2,672,874.29	81,951,107.29
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		0.00	21,346,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.00	21,346,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр		0.00	21,346,500.00
222001	Тоног төхөөрөмж		0.00	10,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		0.00	11,046,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		0.00	-21,346,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		2,672,874.29	60,604,607.29
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	2,672,874.29
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,672,874.29		63,277,481.58

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,048,408,785.54	1,160,828,907.97
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,048,408,785.54	1,160,828,907.97
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1.09	-1.09
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,048,408,784.45	1,160,828,906.88
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	57,697,630.44	57,697,630.44
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,106,106,414.89	1,218,526,537.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	866,772,500.00	802,228,409.60	64,544,090.40	92.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	866,772,500.00	802,228,409.60	64,544,090.40	92.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,772,500.00	802,228,409.60	64,544,090.40	92.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	574,482,100.00	528,261,944.83	46,220,155.17	92.0
210101	Үндсэн цалин	390,937,200.00	389,387,960.88	1,549,239.12	99.6
210102	Нэмэгдэл	167,775,100.00	120,603,461.40	47,171,638.60	71.9
210104	Урамшуулал	15,769,800.00	18,270,522.55	-2,500,722.55	115.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,903,000.00	71,499,407.88	6,403,592.12	91.8
210201	Тэтгэврийн даатгал	52,974,400.00	48,709,640.56	4,264,759.44	91.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,232,600.00	5,730,845.94	501,754.06	91.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,985,500.00	4,566,316.78	419,183.22	91.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,246,300.00	1,129,782.40	116,517.60	90.7
210205	Эрүүл мэндийн даатгал	12,464,200.00	11,362,822.20	1,101,377.80	91.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,220,300.00	61,957,716.89	1,262,583.11	98.0
210301	Гэрэл, цахилгаан	9,805,200.00	8,823,015.77	982,184.23	90.0
210302	Түлш, халаалт	44,738,900.00	44,992,651.12	-253,751.12	100.6
210303	Цэвэр, бохир ус	8,676,200.00	8,142,050.00	534,150.00	93.8
2105	Нормативт зардал	89,981,400.00	80,514,860.00	9,466,540.00	89.5
210502	Хоол, хүнс	89,981,400.00	80,514,860.00	9,466,540.00	89.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,466,000.00	4,000.00	99.9
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,466,000.00	4,000.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,438,600.00	284,014.00	1,154,586.00	19.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,438,600.00	284,014.00	1,154,586.00	19.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,950,800.00	31,918,166.00	32,634.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,635,000.00	27,612,900.00	22,100.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,315,800.00	4,305,266.00	10,534.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,026,300.00	14,026,300.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,026,300.00	14,026,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,026,300.00	14,026,300.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,300,000.00	10,300,000.00	0.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	10,300,000.00	10,300,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	866,772,500.00	862,833,016.89	3,939,483.11	99.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	853,799,600.00	852,533,016.89	1,266,583.11	99.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	787,109,300.00	787,109,300.00	0.00	100.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,690,300.00	65,423,716.89	1,266,583.11	98.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,972,900.00	10,300,000.00	2,672,900.00	79.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,300,000.00	10,300,000.00	0.00	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,672,900.00	3.00	2,672,897.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	2,672,874.29		

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	63,277,481.58		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	33	33	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21	21	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	0	100.0
631	ХҮҮХДИЙН ТОО	195	163	32	83.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 6 дугаар цэцэрлэг нь “Боловсролын салбарын хөгжлийн бодлогод нийцүүлэн, гэр бүл, хамт олноо дээдэлсэн эрүүл, аз жаргалтай, төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлага дэг журмыг сахисан, багаар ажиллах чадвартай шилдэг арга зүйтэй, мэргэшсэн чадварлаг боловсон хүчинтэй эцэг эх, олон нийтийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн хүүхдэд ээлтэй байгууллага болно” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын удирдлагыг боловсронгуй болгох /боловсон хүчний нөөц, биет нөөц, санхүүгийн нөөц/,
- Хүүхэд хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах, хөгжүүлэх үйл ажиллагааны арга зүй, хүүхэд бүрийн хөгжлийн ахицад тулгуурлах,
- Сургалтын таатай орчин бүрдүүлэх /засвар үйлчилгээ, орчны тохижилт/,
- Цэцэрлэгийн үйл ажиллагааны тогтвортой хөгжил, нийгмийн хүрээн дэх түншлэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:

1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",

2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,697.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,672.9	63,277.5	60,604.6
Авлага			
Бараа материал	19,656.6	27,006.1	7,349.5
Үндсэн хөрөнгө	1,138,499.4	1,128,242.9	(10,256.5)
Нийт хөрөнгө	1,160,828.9	1,218,526.5	57,697.6
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,160,828.9	1,218,526.5	57,697.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,160,828.9	1,218,526.5	57,697.6

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 63,277.5 мянган төгрөг болж 60,604.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 27,006.1 мянган төгрөг болж 7,349.5 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-аас 100.0 мянган төгрөгийн ном сэтгүүл, 99,451.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 92,201.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,128,242.9 мянган төгрөг болж 10,256.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 21,346.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон тайлант онд 31,603.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 642,102.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,653.3 мянган төгрөг, нийт 694,755.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 86,726.7 мянган төгрөгөөр буюу цалин хөлсийг 64,027.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 20,880.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,547.1 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 990.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 718.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 608,028.6 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин, НДШ-ийн зардлыг 182,668.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 14,037.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 26,045.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 11,666.5 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 14,026.3 мянган төгрөгөөр нийт 248,443.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 787,109.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 66,690.3 мянган төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас тоног төхөөрөмж худалдан авах 10,300.0 мянган төгрөг зэрэг нийт 866,772.5 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 787,109.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 66,690.3 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 10,300.0 мянган төгрөг нийт 866,772.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 802,228.4 мянган төгрөгийг зарцуулж, 64,544.1 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 802,228.4 мянган төгрөг буюу 92.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 53,811.0 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 9,466.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 1,262.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Нэр	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	2,157.9	2,156.8	1.1	99.9
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	89,981.4	80,514.9	9,466.5	89.5
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,436.6	3,436.6	-	100.0
4	81823	Боловсролын байгууллагын багш,	2,187.2	2,166.2	21.0	99.0
5	81834	Боловсролын стандарт, сургалт	518,706.2	486,680.9	32,025.3	93.8
6	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	173,312.9	151,545.3	21,763.6	87.4
7	83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	10,300.0	10,300.0	-	100.0
8	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	66,690.3	65,427.7	1,262.6	98.1
		Нийт	866,772.5	802,228.4	64,544.1	92.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ 89,981.4 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодогчийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 602,666.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,026.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 6 дугаар цэцэрлэг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэггүй, зах зээл хомс гэх шалтгаанаар хүнсний худалдан авалтыг нээлттэй зарлаж, үнийн харьцуулалт хийлгүйгээр иргэдээс болон “Хараа мөнгилмаа” ХХК, “Сая сарнай” ЗБН, “Шанддов” ХХК, “Уужим хараа” ХХК ХХК-иудтай гэрээ байгуулан шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Худалдан авах ажиллагааг “Худалдан авах ажиллагааны босго үнийн журам”-ын хүрээнд ил тод, нээлттэй зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 224 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 1,752.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж					
Албан шаардлага	1	1,752.8	1	1,752.8	100.0
Нийт дүн	1	1,752.8	1	1,752.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан”** гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **1,378.2** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Д.Ариунжаргалд 689.1 мянган төгрөг,
- Нярав П.Долгормаад 689.1 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах **37,295.2** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд цалингийн зардлын 3,993.6 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнасан байна.
- Худалдан авсан 33,301.6 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээд, өөр аж ахуйн нэгжийн нэрээр орлого авсан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт зөрчил¹ илэрч зөвлөмж хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт: Түнхэл тосгоны Захирагчийн албаны үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй Д.Ариунжаргалыг Соёлын төв / үндсэн цалингийн 60.0 хувиар цалинждаг / болон тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрөөр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 80.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх ” Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ” 37.1.17: “Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх”,
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх “Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ”, 38.1.6: “Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх”, 38.1.7:“Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...”,
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх “ Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” зэрэг.

1.2 Өгсөн зөвлөмж: 3 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд 1- ээс илүү зэрэгцээ хөдөлмөр эрхлүүлэхгүй байж, цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 –ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан бараа материалын бэлтгэн нийлүүлэгчийг буруу бүртгэсэн	1	33,301.6			1	33,301.6	1	33,301.6				
Цалингийн зардлыг НДШ-ийн зардлаар тусгасан	1	3,993.6			1	3,993.6	1	3,993.6				
Дүн	2	37,295.2			2	37,295.2	2	37,295.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогчийг давхар ажил эрхлүүлсэн	1							1						
	1							1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Зөвлөмж	
							Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1									1
Дүн	1									1